



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 09 дүгээр сарын 28 өдөр Дугаар 86

Хэрлэн сум

LXXXVI ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 86 дугаар хуралдаан 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 16:00 цагт танхимаар 60,7 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Коронавируст халдварт /Ковид-19/-ын нөхцөл байдлын мэдээллийг танилцуулах,

Аймгийн ерөнхий тархвар судлаач

2. Үхрийн арьс товруутах өвчний нөхцөл байдлын талаар мэдээлэл танилцуулах,

Мал эмнэлгийн газар

3. Өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын талаар мэдээлэл танилцуулах,

Хүнс, хөдөө аж ахуйн газар

4. Хадлан бэлтгэл, ургац хураалтад ажиллаж буй иргэдийг шинжилгээнд хамруулах талаар хэлэлцэх,

Эрүүл мэндийн газар

5. Буяны ажилд хяналт тавих тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөл, ажлын хэсэг мэдээлэл танилцуулах,

Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар

6. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл танилцуулах,

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Бусийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.1. Аймгийн Онцгой комиссын 2021 оны “Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай” 110 дугаар тогтоолын хэрэгжих хугацааг дахин сунгах талаар арга хэмжээ авч аймгийн Онцгой комиссын хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

/ / М.Бадамсүрэн
/ / х/а Г.Нармандах

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа-д:

1.2. Тандалтын багийг өргөжүүлж ажиллах, бүтцийг шинэчлэн томилгоожуулах тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөл танилцуулж батлуулах,

1.3. Тандалтын багт шаардагдах зардлын тооцоог гаргаж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

Хоёр. Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Аюушмаа-д:

2.1. Ухрийн арьс товруутах өвчинөөс урьдчилан сэргийлэх вакциныг шинээр халдвар бүртгэгдсэн айл, өрхөд эхний ээлжид эрэмбэлэн оновчтой хуваарилах ажлыг зохион байгуулах,

2.2. Ухрийн арьс товруутах өвчний сэжигтэй бүсэд хамарагдаж буй айл, өрхүүдийн малыг 2 дугаар ээлжийн эрэмбэд оруулж вакцинжуулалтад хамруулах,

Гурав. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандаа,
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ж.Алимаа нарт:

3.1. Аймгийн аюулгүйн нөөцөд байгаа үнэ чөлөөлсөн 108тн өвсийг үнэ чөлөөлсөн шийдвэрийг цуцалж, хаврын улиралд малчдад олгох тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ж.Алимаа-д:

3.2. Аймгийн аюулгүйн нөөцөд байрлаж буй 108тн өвс, тэжээлийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллах,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын
орлогч дарга Ч.Ганбат-д:

3.3. Сумын аюулгүйн нөөцөд байх шаардлагатай өвс, тэжээлийг бэлтгэх ажлыг шуурхай зохион байгуулах талаар сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт цахим хурлаар чиглэл өгч ажиллах,

Сумын Засаг дарга, Онцгой комиссын
дарга нарт:

3.4. Сумын аюулгүйн нөөцөд байх шаардлагатай өвс, тэжээл бэлтгэх ажлыг шуурхай зох~~мон~~ байгуулах,

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ж.Алимаа,
Орон нутгийн өмчийн газрын дарга М.Нямсүрэн нарт:

3.5. Аймгийн аюулгүйн нөөцөд байх шаардлагатай хивэг тэжээлийг худалдан авах ажлыг шуурхай зохион байгуулах,

/  / М.Бадамсүрэн
/  / x/a Г.Нармандаа

Дөрөв.Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир,

4.1.Аймгийн Онцгой комиссын тогтоолоор баталсан “Буяны ажилд хяналт тавих тухай түр журам”-ын оршуулгын үйл ажиллагаанд 10 хүртэл хүн, 5 хүртэл тээврийн хэрэгсэл, цайллагад 25 хүртэл иргэнийг оролцуулах талаар өөрчлөлт оруулж шинэчлэн батлуулах,

Тав.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,
Хадлан, ургац хураалтын ажилд хяналт тавих
ажлын хэсгийн ахлагч нарт:

5.1.Хадлан, ургац хураалтад ажиллаж буй ажилчин, иргэдийг коронавирус илрүүлэх шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа-д:

5.2.Хадлан, ургац хураалтад ажиллаж буй иргэдийг коронавирус илрүүлэх түргэвчилсэн шинжилгээнд хамруулахад шаардагдах 1000 ширхэгийг худалдан авахад зардал 12,500,000 төгрөгийг аймгийн Засаг даргын зөвлөлийн дараагийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын
орлогч дарга Ч.Ганбат-д:

5.3.Хадлан, ургац хураалтын үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийн үйл ажиллагаанд хамрагдаагүй аж ахуй нэгж, бригадын ажилчдыг коронавирус илрүүлэх шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах талаар сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт чиглэл өгөх,

Зургаа.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

6.1.Улаан бүсэд буюу өрхийн Эрүүл мэндийн төв, коронавирус илрүүлэх шинжилгээний цэгүүдэд ажиллаж буй албан хаагч нарын дархлааг дэмжих зорилгоор витагрипп 10 хайрцаг, хуурай аарц 325 ширхэг, энэргийн ундаа 50 ширхэгийг тус тус Дотоодын хүмүүнлэгийн тусlamжийн сангаас Эрүүл мэндийн газарт олгох,

6.2.Чойбалсан хотын нийтийн эзэмшилийн гудамж, талбайд коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх зарлан мэдээллийг хүргэхэд шаардагдах шатахууны зардал 217,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусlamжийн сангаас Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газарт олгохыг тус тус үүрэг болгов.

